



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 2 сарын 26 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

### VII ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын VII хурал 2020 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 13:00 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдварын (COVID-19) шинээр үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;

2. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гадаад харилцааны чиглэлээр зохион байгуулж буй ажлын тухай Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар;

3. Коронавируст халдвар (COVID-19) нэмэгдэж буй БНСУ, Япон Улсад хийх нислэгийн хөдөлгөөнийг зохицуулах болон улс, хот хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээний тухай Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан нарын мэдээллийг сонсов.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан Улсын онцгой комиссын тогтоол, иргэд, олон нийтэд хандан уриалга гаргахаар тус тус тогтов.

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга,

Монгол Улсын сайд Л.Оюун-Эрдэнэ,

Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан нарт:

1.1 Дэлхий дахинд тархаад буй короновируст халдварын тархалтын нөхцөл байдалтай холбогдуулан гадаадын зээл, тусламжаар Монгол Улсад хэрэгжүүлж буй томоохон төсөл, хөтөлбөрийн явц, цаашдын төлөв байдлын талаар Улсын онцгой комисс, Засгийн газарт танилцуулах;

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,

Гаалийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

2.1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж (амьсгалын болон утлагын аппарат, хяналтын монитор зэрэг тоног төхөөрөмж), ариутгал, халдваргүйжүүлэх бодисыг нийлүүлэгч улс орноос тээвэрлэх, нэвтрүүлэх асуудлыг шуурхай зохион байгуулж, шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, бусад ачаа барааг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын зардлаар тээвэрлэх ажлыг зохион байгуулах;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

3.1. БНСУ, Япон Улс руу үйлдэх 2 талын нислэгийг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн шуурхай авч хэрэгжүүлэх;

3.2. Улаанбаатар-Берлин-Улаанбаатар, Улаанбаатар-Москва-Улаанбаатар, Улаанбаатар-Истанбул-Улаанбаатар, Улаанбаатар-Астана-Улаанбаатар, Улаанбаатар-Эрхүү-Улаанбаатар, Улаанбаатар-Улаан-Үүд-Улаанбаатар чиглэлийн хуваарьт нислэгт онцгой анхаарал хандуулж, холбогдох яам, агентлагтай хамтран ажиллах;

3.3. Монгол Улс, Япон Улс хоорондын нислэгийн тийзийг шимтгэлгүй буцаах, дамжин өнгөрөх зорчигчийн нислэгийг зохицуулах;

3.4. Орон нутгийн нисэх буудлуудад агаарын хөлөг буух, хөөрөх үеэр аймгийн мэргэжлийн хяналтын байгууллага зорчигчийн халууныг хэмжих, сэжигтэй тохиолдол илэрвэл холбогдох арга хэмжээг авч ажиллах;

Дөрөв. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Д.Чинзориг  
Гадаадын иргэн, харъяатын газрын дарга Д.Мөрөн нарт:

4.1. БНСУ дахь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд татан оролцуулж, Монгол Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яамны шууд удирдлага дор ажиллуулах;

4.2 Монгол Улсад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд ажиллаж буй гадаадын иргэдийн судалгааг гаргаж, виз, нэвтрэх зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх, төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;

Тав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан,  
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат,  
Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,  
аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газруудад:

5.1. Коронавируст (COVID-19) халдварын дэгдэлт, нөхцөл байдалтай холбогдуулж халдваргүйжүүлэлтийн бодис, уусмалын жагсаалтыг олон улсад хэрэглэгдэж байгаа бодисын жагсаалтад нийцүүлэн шинэчлэн тогтоох;



5.2. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийг тогтоох, цаашид импортлох улсыг сонгох асуудлыг судалж холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэх;

5.3. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй архи, спиртын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг ариутгал, халдваргүйжүүлэлтэд хэрэглэх ажлыг зохион байгуулах;

Зургаа. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү  
Гаалийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт нарт:

6.1. Халдваргүйжүүлэлтийн тусгай зөвшөөрөл олголт, халдваргүйжүүлэлтийн бодисын импорт, хадгалалт, тээвэрлэлт, хэрэглээ, үйл ажиллагаанд хяналт тавих;

Долоо. Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,  
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумьяабазар  
МХЕГ-ын дарга Н.Цагаанхүү,  
Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт,  
Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь,  
Ховд аймгийн Засаг дарга,  
холбогдох аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад:

7.1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах бэлтгэл ажлыг 2020 оны 03 дугаар сарын 15-ны дотор бүрэн хангах арга хэмжээ авах;

7.2. Нүүрс болон газрын тосны тээвэрлэлтийг сэргээх бэлтгэл ажлын хүрээнд хилийн боомтуудад шуурхай ажлын хэсгийг томилон ажиллуулж, удирдлага зохицуулалтаар хангаж, дүнг Улсын онцгой комисст танилцуулах;

Найм. Сангийн сайд Ч.Хүрэлбаатар,  
Барилга, хот байгуулалтын сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Х.Баделхан нарт:

8.1. Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайтын хилийн боомтыг шинэчлэх төслийн ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах;

Ес. Аймаг, нийслэлийн Засаг дарга,  
Онцгой комиссын дарга нарт:

9.1. Коронавируст (COVID-19) халдварын нөхцөл байдалтай холбогдуулан нутаг, дэвсгэрийн хэмжээнд бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, аймаг нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч ажиллах;

9.2. Коронавируст (COVID-19) халдварын илэрхий шинж тэмдэг (ханиасан, халуурсан, хатгаатай гэх мэт) -тэй хүнийг шууд эмнэлгийн байгууллагад тусгаарлаж, холбогдох тандалт судалгаа, эмчилгээ хийх;

9.3. Коронавируст халдвар гарсан улс оронд оршин сууж байсан, дамжин өнгөрсөн, халдвартай хүнтэй болон сэжиг бүхий хүнтэй хавьтал болсон (хамт байсан, нэг унаанд суусан зэрэг) өгүүлэмжтэй хүмүүсийг тусгаарлах байранд 14 хоног өөрсдийнх нь зардлаар тусгаарлаж, шинжилгээний хариу гартал ажиглалт хийх;

9.4. Тусгаарлах болон ажиглалт хийх байрыг бэлтгэхтэй холбогдуулан гарах зардлыг орон нутгийн нөөц боломжийг дайчлан, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран шийдвэрлэхийг тус тус үүрэг болгов.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОГЧ ГҮЙЦЭТГЭГЧ,  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

A large, stylized handwritten signature in black ink, which appears to read "Г. Ариунбуян".

Г.АРИУНБУЯН